



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Нийгмийн даатгалын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/40/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2026 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас:7034-2580 Цахим хаяг: Bulgan@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас:9905-7478 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: С.Цэдэнлхам Утас:9982-8263 Цахим хаяг: Tsedenkham@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.09.24 № 112
танай _____ ны № _____ т

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/38 дугаар тушаалаар 2025 оныг "Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бууруулах жил" болгон зарласан байна.

Бусад асуудлын хэсэг

6328050947

Тайлант онд Нийгмийн даатгалын газар нь Итгэлцлийн аян, Ажил олгогчийн зөвлөгөөн, ХАБЭБ сургалт, Даатгуулагчийн сарын аян зэрэг арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан ажилласан байна. 2025 онд төрийн албан хаагчийн цалин, тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлсэн, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 хувиар нэмэгдүүлж, 792 мянган төгрөг болгосон холбогдуулан хууль тогтоомжийг иргэд, даатгуулагчдад сурталчлах, сургалт зохион байгуулах, хуваарийн угтах үйлчилгээний байцаагчийг ажиллуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

	(мянган төгрөгөөр)	
Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	31,733.6	4,194.7
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,057,969.3	1,054,408.7
Нийт хөрөнгийн дүн	1,089,702.9	1,058,603.4
Нийт өр төлбөрийн дүн	-	2,735.0
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,089,702.9	1,055,868.4
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,089,702.9	1,058,603.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,703,928.6	1,841,405.6
Үйл ажиллагааны зардлын дүн	1,736,384.4	1,875,116.9
Үйл ажиллагааны үр дүн	(32,455.8)	(33,711.3)
Үйл ажиллагааны бус үр дүн	-	(123.2)
Үйл ажиллагааны нийт үр дүн	(32,455.8)	(33,834.5)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,122,158.7	1,089,702.9
Тайлант оны үр дүн	(32,455.8)	(33,834.5)
Эцсийн үлдэгдэл	1,089,702.9	1,055,868.4
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,698,723.1	1,768,790.3
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,666,196.4	1,768,940.0
Үйл ажиллагааны ЦМГ	32,526.7	(149.7)
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(32,526.7)	-
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	(149.7)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	149.7	149.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	149.7	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,613,767.3	1,616,748.1
Урсгал зардал	1,613,767.3	1,616,748.1
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,613,767.3	1,616,748.1
Улсын төсвөөс санхүүжих	1,613,767.3	1,616,748.1
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын газар нь эрхэм зорилгоо “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ. Манай байгууллага 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий Даатгагч болно. Нийгмийн даатгалын байгууллага нь өсөн дэвших эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцөд түшиглэн үйл ажиллагаагаа цаг үргэлжид сайжруулан, түншлэл хамтын ажиллагааг дэмжин, харилцан үр ашигтай хамтран

ажиллаж, сайн засаглалыг хэрэгжүүлэн, хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээг ДААТГУУЛАГЧДАД хүргэнэ” гэж тодорхойлсон байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/38 дугаар тушаалаар 2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бууруулах жил” болгон зарласан. Жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг ханган дараах үйл ажиллагаа ажилттай зохион байгуулсан байна. Үүнд.

- Итгэлцлийн аян
- Ажил олгогчдын зөвлөгөөн
- Нийгмийн даатгалын тухай хуулийн шинэчлэлт, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан хууль тогтоомжийг даатгуулагчдад сурталчлан таниулах
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт
- Нийгмийн даатгалын нийт албан хаагчдыг чадавхжуулах, хөрвөх чадвар олгох Хойд бүсийн сургалт
- Даатгуулагчийн сар аян
- Угтах үйлчилгээний байцаагч ажиллуулах

Тайлант онд аймгийн Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөөг 12 зорилтын хүрээнд 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 83.4 хувь, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилт, 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 83.9 хувьтай үнэлүүлэн “**хангалттай**” үнэлгээ авсан байна.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийгмийн даатгалын газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Тэтгэврийн даатгалын тухай, Тэтгэмжийн даатгалын тухай, Ажилгүйдлийн даатгалын тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай, Татварын багц, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд яамны үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга;
- Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Сангийн сайдын холбогдох журам зааварт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

Тайлант онд Нийгмийн даатгалын газар нь Итгэлцлийн аян, Ажил олгогчийн зөвлөгөөн, ХАБЭБ сургалт, Даатгуулагчийн сарын аян зэрэг арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан ажилласан байна. 2025 онд төрийн албан хаагчийн цалин, тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлсэн, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 хувиар нэмэгдүүлж, 792 мянган төгрөг болгосон холбогдуулан хууль тогтоомжийг иргэд, даатгуулагчдад сурталчлах, сургалт зохион байгуулах, хуваарийн угтах үйлчилгээний байцаагчийг ажиллуулсан байна.

Тав. Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/38 дугаар тушаалаар 2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бууруулах жил” болгон зарласан байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Нийцлийн асуудлаар илэрсэн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд нийт 29 төрлийн 183 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс хугацаа болоогүй 5 мэдээлэл байна. 176 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг 2 удаа хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш 2,043.1 сая төгрөгийн 43 орлогын, 702.1 сая төгрөгийн 45 зарлагын гүйлгээг бүрэн мэдээлж ажилласан байна.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хүний нөөц, Цалин хөлстэй холбоотой шийдвэрийг хууль, дүрэм журмын дагуу гаргаж байхад анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Найм. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 42.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1.6 сая төгрөгийн 1 алдааг залруулж, залруулагдаагүй 6.5 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт, 0.7 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өглөө.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 6.5 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 11.5 сая төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Төлбөрийн акт

1.Төрийн захиргааны алба хаасан хугацааны нэмэгдлийг 3 албан хаагчид үндэслэлгүйгээр илүү тооцож 1.0 сая төгрөгийг олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам" зөрчсөн нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

2.Төрийн захиргааны алба хаасан хугацааны нэмэгдлийг 2 албан хаагчид үндэслэлгүйгээр дутуу тооцож 0.3 сая төгрөгийг олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам" зөрчсөн нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3.Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэсэн нэмэгдлийн цалин, урамшуулалд 3.6 сая төгрөгийг 2 албан хаагчид олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 42, 43 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам", санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

4.Төсвийн шууд захирагчийн 2025 оны 3, 4 дүгээр улирлын ажлын үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээний урамшууллыг 1.0 сая төгрөгөөр хэтрүүлэн олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам", санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

5.Хөдөлмөр, хамгаалал хувцас эдийн засгийн ангиллаас зарцуулсан Гамшгийн иж бүрэн сургуулилтад зарцуулсан 0.5 сая шатахуун нь жолоочийн тооцооны хуудасгүй, анхан шатны баримтгүй, эдийн засгийн ангилал зөрчсөн байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.1,

16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2025 оны зөрчсөн нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

1.Өмнөх онд олгогдоогүй 1 төрийн албан хаагчийн орон нутгийн нэмэгдлийг нөхөн олгохдоо илүү цагийн нэмэгдэл хөлсөөр орлуулан олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.17 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам, 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам", санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(сая төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд 1.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцооны үлдэгдлийн баталгааны маягтаар баталгаажуулаагүй.	1	1.6					1	1.6				
Дүн	1	1.6					1	1.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг орлон гүйцэтгэсний нэмэгдлийг илүү олгосон.	1	3.6	1	3.6								
Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү тооцож олгосон.	1	1.0	1	1.1								

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг дутуу тооцож олгосон.	1	0.3	1	0.3								
Төсвийн шууд захирагчид ажлын үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний урамшууллыг илүү тооцож олгосон.	1	1.0	1	1.0								
Жолоочийн тооцооны хуудасгүй, анхан шатны баримтгүй, эдийн засгийн ангилал зөрчиж хөрөнгө зарцуулсан.	1	0.5	1	0.5								
Орон нутгийн нэмэгдлийг нөхөн олгохдоо илүү цагийн нэмэгдэл хөлсөөр орлуулан олгосон.	1	0.7			1	0.7						
Дүн	6	7.2	5	6.5	1	0.7	-	-				